

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 65.020.40

Сөөгний суулгац. Ерөнхий шаардлага	MNS 6255 : 2011
Seedlings of shrubs. General requirement	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлав.

Энэ стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

## 1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь хот, суурин газрын нийтийн эзэмшил, хязгаарлагдмал хэрэгцээний болон тусгай зориулалтын ногоон байгууламжийн талбайг цэцэрлэгжүүлэхэд зориулан мод үржүүлгийн газарт ургуулсан, ойгоос авах сөөгний суулгац (монос, долоогоно, өрөл, далан хальс, голтбор, сарнай, чаргай, шар мод, яргай, улаагана, харгана зэрэг)-ыг сонгон ухаж авах, хамгаалах, савлах, хаяглах, тээвэрлэх, шалгаж хүлээн авах, суулгахад хамаарна.

## 2 Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах баримт бичгийг иш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны материалаас иш татаж хэрэглэнэ.

- MNS 2783 : 2005, Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн.
- Мөөгөнцөрийн өвчнийг илрүүлэх арга.
- MNS 2784 : 2007, Ургамал, ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн. Бактерийн гаралтай өвчнийг илрүүлэх арга.
- MNS 6139 : 2010, Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага.
- MNS 6141 : 2010, Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага.
- ГОСТ 24835-81, Мод, сөөгний суулгац. Техникийн шаардлага.
- ГОСТ 26231-84, Нохойн хошууны тарьц ба суулгац. Техникийн шаардлага.
- ГОСТ 26869-86, Чимэглэлийн сөөгний суулгац. Техникийн шаардлага.
- ГОСТ 27635-88, Голтбор, сортын сарнайн суулгац. Техникийн шаардлага.

## 3 Нэр томъёо, тодорхойлолт

### 3.1

#### Сөөг

Гол ишгүй, үндэсний хүзүүнээс дээш адил хэмжээний олон иштэй 5 метр хүртэл өндөр ургадаг модлог ургамал,

### 3.2

#### Суулгац

Бойжуулгын талбайд шилжүүлэн суулгаж ургуулсан 2-оос дээш настай модлог ургамал.

## 4 Ангилал

Сөөгний суулгацыг хэмжээ ба чанараар нь I, II, III зэрэг гэж ангилна.

**5 Техникийн шаардлага**

**5.1** Сөөгний суулгацын зэрэг нь 1-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

1-р хүснэгт

Д/д	Үзүүлэлт	Хэмжээ ба шаардлага /зэрэг/		
		I	II	III
1	Гадаад байдал	Гадна талын өнгө байдал хэвийн, шалбарч гэмтээгүй, өвчин, хортонд нэрвэгдээгүй, нахиа нь хугацаанаасаа эрт задраагүй, мөчир, үндэс ихтэй, гувар нь эгц шулуун бат бэх, хугараагүй, өсөлт хөгжилт сайтай байна.		
2	Хэлбэр	Титэм зөв хэлбэртэй		
3	Хэмжээ а) сөөгний өндөр, м	1,2-1,5	0,9-1,1	0.6-0,8
	б) Үндсэн мөчрийн тоо	9-10	8-9	6-8
4	Үндэс	Салаалсан үндэс ихтэй бөгөөд өсөлт, хөгжилт сайтай байхын дээр үржил шимтэй шорооны хамт байна.		
	а) үндэстэй нь хамт авсан үржил шимтэй шороотой хэсгийн голч, см	35-40	30-34	20-29
	б) үндэстэй нь хамт авсан үржил шимтэй шороотой хэсгийн зузаан, см	25-30	20-24	15-19

**5.2** Суулгацыг хавар газар гэссэний дараа тайван байдалд байхад 4 дүгээр сарын 15-аас 5 дугаар сарын 25 хүртэл, намар тайван байдалд орсон үед 10 дугаар сарын 1-ээс 11 дүгээр сарын 1-ний дотор суулгана.

**6 Шалгаж хүлээн авах**

**6.1** Суулгацыг хавар тарилт хийхээс өмнө буюу 5 дугаар сарын 1-р арав хоногт, намар тарихын өмнө 10 дугаар сарын 2-р арав хоногт багтаан шалгаж хүлээн авна.

**6.2** Сөөгний суулгацын стандартыг 1-р хүснэгтэд заасан шаардлагыг баримтлан нийт суулгацын 10-аас доошгүй хувийг шалгаж хүлээн авна.

**6.3** Суулгацын урт болон голчыг шугам ба штангенциркулиар хэмжинэ.

**6.4** Сөөгний суулгацын бактер, мөөгөнцөрийн өвчнийг MNS 2783:2005, MNS 2784:2007 стандартын дагуу тодорхойлно.


**6.5** Суулгацын чанар нь энэ стандартын шаардлага хангахгүй бол нийлүүлэгчээс хүлээн авахыг зөвшөөрөхгүй.

**7 Боох, хаяглах, хадгалах, тээвэрлэх**

**7.1 Суулгацын үндсийг боох**

Салхинаас үндэсийг хамгаалан 150 см урт, 100 см өргөн нийлэг хальс, таар шуудайн дээр чийглэсэн үртсийг жигд тараагаад, суулгацын үндсийг шороон

зуурмагт хутгаж, үзүүрийг нэг тийш нь харуулж тавиад суулгацыг өөр хоорондоо үрж холхихгүйгээр модны үртэс буюу шороогоор хөдөлгөөнгүй чигжисний дараа үндэсний хэсгийг таараар битүү дугуйлан бооно.



1-р зураг.  
Суулгацыг ойр тээвэрлэхэд  
бэлтгэх



2-р зураг.  
Суулгацыг хол тээвэрлэхэд  
боож бэлтгэсэн байдал

**7.2** Суулгацыг 50 эсвэл 100 ширхэгээр боож, хаягийг тээвэрлэлтийн үед тасарч гээгдэхээс хамгаалан боодлын гадна ба дотор талд зүүнэ.

### 7.3 Хаяглах

Боодолтой суулгацанд дараах зүйл бүхий шошго нааж хаяглана.

- Суулгац үйлдвэрлэгч байгууллага, аж ахуйн нэгжийн нэр
- Стандартын дугаар
- Зүйл, сортын нэр
- Суулгацын тоо, ширхэг
- Он, сар, өдөр

### 7.4 Хадгалах

Мод үржүүлгийн газраас авсан суулгацыг тарих хүртэл түр хугацаагаар хадгалахдаа үндэсний хэсгийн чийгийг алдагдуулахгүйгээр нүх, шуудуунд хийж 15-аас 20 см зузаан чийгтэй шороо, элс, үртэсээр хучиж, нягтруулж хадгална.

**7.4.1** Намар хүлээж авсан суулгацыг өвөлжүүлэхдээ 40-50 см гүн шанг салхины хөндлөн татаж, уг суулгацыг тэр нутгийн салхины зүгийн дагуу налуулж, нэг нэгээр эгнүүлэн тавиад, үндэсний хэсгийг 30-аас 40 см зузаан шороогоор хучиж, ханатал усална.

### 7.5 Тээвэрлэх

Боодолтой суулгацыг тээврийн хэрэгслээр тээвэрлэхдээ босоо байдлаар эгнүүлэн тавьж доор нь 10-аас 15 см зузаан зөөлөвчтэй ачих бөгөөд боодлын хоорондох

## **MNS 6255 : 2011**

зай завсарт чийгтэй үртэс болон шороогоор чигжиж дүүргэнэ. Хол тээвэрлэх бол үндсийг тогтмол чийглэж хатахаас хамгаална.

**7.5.1** Суулгацыг 4 хоног хүртэл тээвэрлэнэ.

**7.5.2** Суулгацыг авах, суулгахдаа агротехникийн шаардлагыг баримтлана.

**7.5.3** Суулгацын зэрэг бүхэнд хавсралтад дурдсан паспортыг дагалдуулна.

**ТӨГСӨВ.**

**ХАВСРАЛТ  
(Норматив)**

**ПАСПОРТЫН <sup>1</sup>**

Суулгацын нэр.....  
(суулгацын төрөл, зүйл, нас, хэсэг дахь ширхэг)

Өгсөн.....  
( мод үржүүлгийн газар, ойгоос )

**1. Чанарын үзүүлэлтүүд**

Суулгацын чанарын анги	Суулгацын техникийн нөхцөл буюу стандартын нэр ба дугаар	Суулгацын тоо	
		Ширхэг	Бүх хэсэг дэх хувь
I			
II			
III			

Суулгацыг ухаж авсан хугацаа .....

Явуулсан хугацаа .....

Ой хамгаалагчаас суулгацыг явуулахыг зөвшөөрч олгосон баримт  
(ой хамгаалагчийн нэр, он, сар, өдөр <sup>1</sup>...)

**2. Гарал**

Суулгац сонгон авсан газар .....

(мод үржүүлгийн газар, аймаг, сум, газрын нэр)

Паспорт <sup>1</sup> ..... суулгацыг хэн хэдийд өгсөн .....

**3. Ургуулах нөхцөл**

Мод үржүүлгийн газрын нэр ба орших газар нь .....

Мод үржүүлгийн газрын хөрс .....

Суулгацын өвчин, хөнөөлт шавьжид нэрвэгдсэн байдал ба цаг уурын нөлөөллийн  
тухай тэмдэглэл .....

Паспорт олгосон .....он .....сар .....өдөр.....

Байгууллагын удирдагч .....

Хариуцлагатай мэргэжилтэн .....

201... оны ... сарын ... өдөр